



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын Тусгай үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 46,200,000.00 (дөчин зургаан сая хоёр зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Иргэний нисэхийн ерөнхий газрын Тусгай үйлчилгээний албаны дарга С.Нацагдоржид дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001701

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн  
189 дугаар тогтоолын хавсралт



**Иргэний нисэхийн ерөнхий газрын тусгай үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
акталж, данснаас хасах автомашины жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2017 оны 497 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ шинэчлэн тогтоосон
1	"УАЗ-2206" марк, 67-44 УНП улсын дугаартай, арлын дугаар-80469149	2009	280757	16,100,000.00	2,000,000.00	200,000.00
2	"УАЗ-2206" марк, 65-81 УНЛ улсын дугаартай, арлын дугаар-ХТТ2206АО433313	2011	340803	20,200,000.00	2,000,000.00	200,000.00
3	"УАЗ-2206" марк, 16-71 УБЯ улсын дугаартай, арлын дугаар-50450657	2005	385195	9,900,000.00	2,000,000.00	200,000.00
				46,200,000.00	6,000,000.00	600,000.00
	<b>Нийт дүн</b>			<b>46,200,000.00 (дечин зургаан сая хоёр зуун мянган)</b>	<b>6,000,000.00 (зургаан сая)</b>	<b>600,000.00 (зургаан зуун мянган)</b>